



I-IV/2022

Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 13



Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 4 дүгээр сард өмнөх сараас 0.9 хувиар буурлаа

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 4 сард 9.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 (33.3%) их наяд төгрөгөөр өслөө.

Үүнд шатахууны бөөний болон жижиглэн худалдаа 1.2 (60.0%) их наяд төгрөг, хүнсний бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа 376.3 (23.6%) тэрбум төгрөг, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа 141.2 (30.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 4 дүгээр сард 2.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 23.4 (0.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО¹, жил бүрийн эхний 4 сарын байдлаар


	2020		2021		2022*		2022* I-IV 2021 I-IV
	IV	I-IV	IV	I-IV	IV	I-IV	
	тэрбум төгрөг						хувь
Бүгд	1 472.3	6 051.6	1 687.9	7 224.0	2 627.5	9 629.8	133.3
Бөөний худалдаа	565.8	2 258.6	670.3	2 850.3	1 045.3	3 887.8	136.4
Жижиглэн худалдаа	906.5	3 793.1	1 017.6	4 373.7	1 582.3	5 742.0	131.3

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын 2022 оны эхний 4 сарын борлуулалтын орлогын 40.4 хувь нь бөөний худалдаа, 59.6 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2022 оны эхний 4 сард 5.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (31.3%) их наяд төгрөг, харин бөөний худалдааны 3.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (36.4%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.


ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, сараар, тэрбум төгрөг



Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 4 дүгээр сард өмнөх сараас 23.4 тэрбум төгрөгөөр буурахад шатахууны бөөний болон жижиглэн худалдаа 71.3 (8.2%) тэрбум төгрөг, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа 22.7 (12.1%) тэрбум төгрөг, хүнс, ундаа, тамхины бөөний худалдаа 17.2 (6.5%) тэрбум төгрөгөөр, моторт тээврийн хэрэгслийн жижиглэн худалдаа 17.0 (36.4%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 4 сард Төв аймагт өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өссөн бол бусад аймагт 8.4-75.3 хувиар өссөн байна. Харин Өмнөговь аймагт 2022 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, аймгаар, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ;
НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан;

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Л.Энхбаатар
Утас: (976-51)-264797

